



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ФИЗИК ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/51/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитор: Ч.Дашдаваа
Утас: 261628 Цахим хаяг: dashdavaach@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Аккаунт траст аудит ХХК
Захирал П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/304
танай _____-ны № _____-г

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

\\10.10.10.20\Bichg_KheregiYawsan_Bichig\2022\0224 Audit\in2 Gazar-21.Docx

001050204

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>267,259,898.46</u>	<u>322,046,315.50</u>
33	АВЛАГА	714,797.39	33,885,827.89
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	158,062.79	84,111.63
33300	Татаас, санхүүжилтийн авлага	556,734.60	33,801,716.26
34	УРЬДЧИЛГАА	44,000,000.00	41,018,888.79
34600	Урьдчилж гарсан зардал	44,000,000.00	41,018,888.79
35	БАРАА МАТЕРИАЛ	222,545,101.07	247,141,598.82
351	Түүхий эд материал	201,515,994.27	218,452,084.82
35110	Тусгай зориулалттай материал	201,515,994.27	218,452,084.82
354	Хангамжийн материал	21,029,106.80	28,689,514.00
35410	Бичиг хэргийн материал	6,088,939.00	16,900,609.00
35420	Аж ахуйн материал	14,940,167.80	11,788,905.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,208,624,726.37</u>	<u>4,886,154,095.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,208,624,726.37	4,886,154,095.55
392	Биет хөрөнгө	4,924,878,786.37	4,602,408,155.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,212,379,176.30	4,212,379,176.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(283,430,009.66)	(400,892,445.50)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,495,833.25	21,495,833.25
39204	Хуримтлагдсан элэгдэл	(11,822,708.28)	(15,405,347.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,652,682,797.80	1,784,152,156.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(923,739,285.74)	(1,229,563,369.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	374,418,673.00	374,918,573.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(131,584,853.20)	(159,155,584.21)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	203,910.00	203,910.00
39217	Ном	14,275,252.90	14,275,252.90
393	Биет бус хөрөнгө	283,745,940.00	283,745,940.00
39301	Програм хангамж	4,601,840.00	4,601,840.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,601,840.00)	(4,601,840.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	283,745,940.00	283,745,940.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5,475,884,624.83</u>	<u>5,208,200,411.05</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	=
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,475,884,624.83</u>	<u>5,208,200,411.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,475,884,624.83	5,208,200,411.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,804,884,082.53	2,804,884,082.53
51101	Өмч: - төрийн	2,804,884,082.53	2,804,884,082.53
512	Хуримтлагдсан үр дүн	(1,228,927,481.45)	(1,496,611,695.23)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,442,365,022.36)	(1,228,927,481.45)
51220	Тайлант үеийн үр дүн	213,437,540.91	(267,684,213.78)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,899,928,023.75	3,899,928,023.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5,475,884,624.83</u>	<u>5,208,200,411.05</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,366,101,121.42	2,074,408,083.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	429,778,351.42	40,359,083.20
120	Нийтлэг татварын бус орлого	429,778,351.42	40,359,083.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	429,778,351.42	40,359,083.20
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	20,875,470.00	40,359,083.20
1200045	Үнэ төлбөргүй авсан орлого	408,902,881.42	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,936,322,770.00	2,034,049,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,774,890,300.00	1,826,184,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,774,890,300.00	1,826,184,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,432,470.00	207,864,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,150,000.00	21,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,624,200.00	153,635,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,658,270.00	32,968,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,152,821,643.30	2,342,092,296.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,152,821,643.30	2,342,092,296.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,131,492,513.83	2,271,773,354.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,556,469.00	1,320,758,381.00
210101	Үндсэн цалин	1,009,271,843.00	985,022,760.00
210102	Нэмэгдэл	231,883,899.00	235,069,201.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,400,727.00	100,666,420.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,788,109.21	168,203,713.51
210201	Тэтгэврийн даатгал	131,445,104.81	120,794,047.42
210202	Тэтгэмжийн даатгал	12,716,742.21	13,327,076.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,902,875.70	10,493,656.34
210204	Ажилгүйдлийн даатгал	376,531.88	2,077,630.85
210205	Эрүүл мэндийн даатгал	17,346,854.61	21,511,302.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,214,032.00	70,141,900.00
210301	Гэрэл, цахилгаан	41,607,933.96	29,406,353.00
210302	Түлш, халаалт	32,262,116.34	38,274,371.00
210303	Цэвэр, бохир ус	3,343,981.70	2,461,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,493,641.73	23,188,128.57
210401	Бичиг хэрэг	5,672,225.00	3,154,220.00
210402	Тээвэр, шатахуун	704,100.00	517,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,831,229.53	1,770,258.77
210404	Ном, хэвлэл	333,000.00	290,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,440,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,573,087.20	16,016,089.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,080,642.00	36,210,000.00
210604	Урсгал засвар	16,080,642.00	36,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	174,539,279.00	198,831,341.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,815,442.00	195,733,741.69
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,743,837.00	1,117,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	347,662,278.10	454,439,889.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,240,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	345,422,278.10	454,439,889.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,329,129.47	70,318,942.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,270,000.00	3,181,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,270,000.00	3,181,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,059,129.47	67,137,942.62
213301	Төвлөрүүлэн шилжүүлэг /Улсын төсвөөс/	17,059,129.47	67,000,674.62
213305	Төвлөрүүлэн шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/	-	137,268.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>213,437,540.91</u>	<u>(267,684,213.78)</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>213,437,540.91</u>	<u>(267,684,213.78)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,442,365,022.36)	5,262,447,083.92
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,442,365,022.36)	5,262,447,083.92
C08	Тайлант үеийн үр дүн			213,437,540.91	213,437,540.91
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,228,927,481.45)	5,475,884,624.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,228,927,481.45)	5,475,884,624.83
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(267,684,213.78)	(267,684,213.78)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,804,884,082.53	3,899,928,023.75	(1,496,611,695.23)	5,208,200,411.05

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,936,322,770.00</u>	<u>2,034,605,734.60</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,936,322,770.00	2,034,605,734.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,774,890,300.00	1,826,184,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,774,890,300.00	1,826,184,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,432,470.00	208,421,134.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,150,000.00	21,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	135,624,200.00	153,635,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,658,270.00	33,525,234.60
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,875,065,074.00</u>	<u>1,967,195,559.03</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,875,065,074.00	1,967,195,559.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,853,179,209.93	1,863,074,900.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,556,469.00	1,320,758,681.00
210101	Үндсэн цалин	1,009,271,843.00	985,022,760.00
210102	Нэмэгдэл	231,883,899.00	235,069,501.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,400,727.00	100,666,420.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	163,946,172.00	168,287,825.14
210201	Тэтгэврийн даатгал	131,603,167.60	120,878,159.05
210202	Тэтгэмжийн даатгал	12,716,742.21	13,327,076.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,902,875.70	10,493,656.34
210204	Ажилгүйдлийн даатгал	376,531.88	2,077,630.85
210205	Эрүүл мэндийн даатгал	17,346,854.61	21,511,302.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,214,032.00	70,141,900.00
210301	Гэрэл, цахилгаан	41,607,933.96	29,406,353.00
210302	Түлш, халаалт	32,262,116.34	38,274,371.00
210303	Цэвэр, бохир ус	3,343,981.70	2,461,176.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,463,329.53	13,511,011.77
210401	Бичиг хэрэг	3,615,000.00	2,504,400.00
210402	Тээвэр, шатахуун	704,100.00	517,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,831,229.53	1,770,258.77
210404	Ном, хэвлэл	333,000.00	290,160.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,380,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,600,000.00	6,988,793.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,455,030.00	46,967,041.57
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,000,000.00	10,757,041.57
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,365,030.00	-
210604	Урсгал засвар	14,090,000.00	36,210,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	194,304,177.40	243,408,440.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	190,580,340.40	240,310,840.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00
210807	Газрын төлбөр	1,743,837.00	1,117,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,240,000.00	-

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,240,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,885,864.07	104,120,658.88
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,270,000.00	3,181,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,270,000.00	3,181,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	17,615,864.07	100,939,658.88
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	17,059,129.47	67,000,674.62
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг /Нэмэлт санхүүжилт/	556,734.60	33,938,984.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>61,257,696.00</u>	<u>67,410,175.57</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	61,257,696.00	67,410,175.57
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	61,257,696.00	67,410,175.57
2200	Дотоод эх үүсвэрээр	61,257,696.00	67,410,175.57
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	61,257,696.00	67,410,175.57
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(61,257,696.00)</u>	<u>(67,410,175.57)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,826,184,600.00	1,759,183,925.38	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,826,184,600.00	1,759,183,925.38	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,823,888,600.00	1,756,887,925.38	96.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,365,569,600.00	1,320,758,681.00	96.7
210101	Үндсэн цалин	1,167,284,300.00	985,022,760.00	84.4
210102	Нэмэгдэл	62,378,100.00	235,069,501.00	376.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	135,907,200.00	100,666,420.00	74.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,751,900.00	168,287,825.14	88.7
210201	Тэтгэврийн даатгал	127,159,100.00	120,878,159.05	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	15,648,200.00	13,327,076.80	85.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,518,600.00	10,493,656.34	83.8
210204	Ажилгүйдлийн даатгал	3,129,600.00	2,077,630.85	66.4
210205	Эрүүл мэндийн даатгал	31,296,400.00	21,511,302.10	68.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,141,900.00	70,141,900.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	36,017,400.00	29,406,353.00	81.6
210302	Түлш, халаалт	32,044,500.00	38,274,371.00	119.4
210303	Цэвэр, бохир ус	2,080,000.00	2,461,176.00	118.3
2104	Хангамж, бараа материалын зардал	13,511,100.00	13,511,011.77	100.0
210401	Бичиг хэрэг	2,467,500.00	2,504,400.00	101.5
210402	Тээвэр, шатахуун	598,500.00	517,400.00	86.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,820,800.00	1,770,258.77	97.2
210404	Ном, хэвлэл	189,600.00	290,160.00	153.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	909,700.00	1,440,000.00	158.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,525,000.00	6,988,793.00	92.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,460,000.00	74,459,894.57	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	49,840,000.00	49,839,994.57	100.0
210602	Тавилга	500,000.00	499,900.00	100.0
210604	Урсгал засвар	24,120,000.00	24,120,000.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,454,100.00	109,728,612.90	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,356,500.00	106,631,012.90	99.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	1,980,000.00	100.0
210807	Газрын төлбөр	1,117,600.00	1,117,600.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2296000.00	2296000.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,296,000.00	2,296,000.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,296,000.00	2,296,000.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,826,184,600.00	1,759,183,925.38	96.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,826,184,600.00	1,759,183,925.38	96.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,826,184,600.00	1,759,183,925.38	96.3
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	118	108	91.5
620001	Удирдах ажилтан	1	1	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	97	90	92.8
620003	Үйлчлэх ажилтан	20	17	85.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		208,421,134.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ		208,421,134.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		173,597,150.34
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		12,090,000.00
210604	Урсгал засвар		12,090,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		161,507,150.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		161,507,150.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		885,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		885,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		885,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		33,938,984.26
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		208,421,134.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		208,421,134.60
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		21,260,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		153,635,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		33,525,234.60

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 10-ны хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн аудитор Б.Эрдэнэчимэг, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Д.Цэцэгсүрэн, захирал П.Наранцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Физик технологийн хүрээлэн нь Монгол улсад орчин үеийн физик, өндөр технологийн салбаруудад хийгдэж буй суурь болон хавсрага судалгааг тэргүүлэн гүйцэтгэгч, инновацийг хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засаг, оюуны хөгжлийн тулгамдсан асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны түвшинд судлан боловсруулах, шинэ мэдлэг, бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгодог эрдэм шинжилгээний байгууллага юм.

Тус хүрээлэн орчин үеийн онолын физик, их энергийн физик, биофизик, хатуу бие, материал судлал, нанотехнологи, сэргээгдэх эрчим хүч, электроникийн чиглэлээр шинэ мэдлэг, шинэ технологи бүтээж улс орныхоо хөгжилд хүч нэмнэ гэж эрхэм зорилгоо тодорхойлж дараах зорилтуудад хүрэхээр ажиллаж байна. Үүнд:

- Монгол улсад орчин үеийн онолын физик, их энергийн физик, биофизик, хатуу бие, материал судлал, нанотехнологи, сэргээгдэх эрчим хүч, электроникийн чиглэлээр суурь болон хавсрага судалгааг онол, туршилтын өндөр түвшинд тэргүүлэн гүйцэтгэгч байгууллага байна;
- Орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр техник, технологийн шинэчлэл хийж, судалгаа шинжилгээний тулгуур лабораториуд байгуулан ажлын үр дүнгээрээ улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна;
- Гадаад дотоодын эрдэм шинжилгээний байгуулга, их дээд сургуультай идэвхитэй хамтран ажиллана;
- Шинжлэх ухаан, шинэ мэдлэгийг эрхэм болгосон, ажилтан, албан хаагчдын ажиллах, амьдрах бүхий л талын таатай орчин нөхцөлийг цогцлоон бүрдүүлсэн эрдэм шинжилгээний байгууллага болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч БШУС-ын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2021 онд тус хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,131,334.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 21,313.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчилэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 267,684.2 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
			Дүн/3=2-1/	Хувь
Б	1	2		
Авлага	714.8	33,885.8	33,171.0	4,640.6
Урьдчилгаа	44,000.0	41,018.9	(2,981.1)	(6.8)
Бараа материал	222,545.1	247,141.6	24,596.5	11.1
Үндсэн хөрөнгө	4,924,878.8	4,602,408.2	(322,470.6)	(6.5)
Биет бус хөрөнгө	283,745.9	283,745.9	-	-
Нийт хөрөнгө	5,475,884.6	5,208,200.4	(267,684.2)	(4.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,804,884.1	2,804,884.1	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,899,928.0	3,899,928.0	-	-
Хуримтлагдсан үр дүн	(1,228,927.5)	(1,496,611.7)	(267,684.2)	21.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгийн дүн	5,475,884.6	5,208,200.4	(267,684.2)	(4.9)

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Авлага данс Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн авлага 33,801.7 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 84.1 мянган, нийт 33,885.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Урьдчилж гарсан зардал данс тоног төхөөрөмж, химийн бодисны урьдчилгаа төлбөр 30,761.6 мянга, хэвлэлийн зардал, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зардлын урьдчилгаа 10,257.3 мянга, нийт 41,018.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн;
- Бараа материал данс 145,908.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 121,312.3 мянган төгрөгийг зарцуулж дансны үлдэгдэл 247,141.6 мянган төгрөг болж өмнөх оноос 24,596.5 мянган төгрөгөөр өссөн;
- Үндсэн хөрөнгө данс 131,969.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд тайлант оны элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 322,470.6 мянган төгрөгөөр буурсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг 1,950,181.2 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,875,041.2 мянга, хөрөнгийн зардалд 75,140.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 123,316.6 мянга, хөрөнгийн зардлыг 680.0 мянга буюу нийт төсвийг 123,996.6 мянган төгрөгөөр бууруулан 1,826,184.6 мянган төгрөгөөр баталсан ба төсвийг дахин тодотгоогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэх 1,826,184.6 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 1,826,184.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 1,759,183.9 мянган төгрөгийг зарцуулж, 67,000.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,759,183.9 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалин, нэмэгдэл НДШ-ийн зардлыг 66,275.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 725.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/						
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	1,826,184.6	1,759,183.9	67,000.7	96.3
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	1,748,964.6	1,682,689.9	66,275.1	96.2
1.2	80219	Харуул хамгаалалт	23,850.0	23,616.5	233.5	99.0
1.3	80220	Холбооны суваг ашигласны хөлс	51,074.0	50,581.9	492.1	99.0
1.4	80802	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,296.0	2,296.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ШУТС-аас 123,635.9 мянга, БШУЯ-наас 30,000.0 мянга, гэрээт ажлын орлого 21,260.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 32,968.5 мянга, өмнөх оны татаас санхүүжилтийн авлага 556.7 нийт 208,421.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс эд хогшил худалдан авахад 12,090.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 161,507.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 885.0 мянга нийт 174,482.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 33,939.0 мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлснээс, 33,801.7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус хүрээлэн нь 2021 онд захиргаа, менежментийн алба, 6 лаборатори, 3 судалгааны баг гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж, нийт 153,635.9 мянган төгрөгийн 21 төсөл хэрэгжсэн байна.

Эдгээр төслийн 7 нь 2020 онд дуусах төлөвөгөөтэй байсан боловч санхүүжилтээс хамаарч 2021 онд үргэлжилсэн, 2021 онд төлөвлөсөн боловч санхүүжигдээгүй 5 төсөл байна.

Хүснэгт 3. Хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт

Д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	24.6	Шинжлэх ухаан технологи				
1	24.6.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	8.4	6.4	(2.0)	76.2
2	24.6.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	53	51	(2)	96.2
3	24.6.3	Боловсруулсан технологи бүтээгдэхүүн	-	-	-	-
Дундаж хувь						86.2

Тайлант онд Физик технологийн хүрээлэнгийн хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн биелэлт 86.2 хувьтай байгаа нь зарим төслийн санхүүжилт хугацаандаа орж ирээгүйтэй холбоотой байна.

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал болон хөрөнгийн зардалд нийт 1,826,184.6 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,759,183.9 мянган төгрөгийг зарцуулж 96.3 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийн биелэлт түүнийг хэрэгжүүлэхээр баталсан төсвийн гүйцэтгэлийн биелэлтээс 10.1 хувиар дутуу буюу төсвийг хэмнэлттэй зарцуулаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Физик технологийн хүрээлэнгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.

Физик технологийн хүрээлэн нь нийт 2,181,572.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 7,692.6 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулаагүй, тайлант хугацаанд байршуулбал зохих 173 мэдээллээс 171-ийг хугацаанд нь бүрэн байршуулж, 2 мэдээллийн хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй,

нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд батлагдсан төсөвт зардлын гүйцэтгэл 1,759,183.9 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолд заасан 10 хувьд хүрээгүй, мөн бичиг хэргийн зардал 1,5 хувь буюу 36.9 мянга, түлш халаалтын зардал 19.4 хувь буюу 6,229.9 мянга, цэвэр бохир усны зардал 18.3 хувь буюу 381.2 мянга нийт 6,647.9 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, төсөвт зардлыг хэмнэж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.5, 1.6 заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар нийт 67,029.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 3 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэх талаар өгсөн 1 зөвлөмжийг биелүүлээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 54,316.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 222,545.1 мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 100.0 хувь, шилэн дансны цахим хуудсанд 8 мэдээг хугацаа хоцроож, 3 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлт 98.2 хувь байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	222.5	2	222.5	98.2
Зөвлөмж	2	54.3	2	54.3	100.0
Нийт дүн	4	276.9	4	276.9	99.1

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 481,053.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 473,360.5 мянга төгрөгийн алдааг залруулж, 7,692.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг 155,208.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн хураангуй, дэлгэрэнгүй бүртгэлийн эхний үлдэгдэл 203.9 мянга, орлогын дүн 853.0 мянга, нийт 1,056.9 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн тайлант онд байгуулсан элэгдлийн зардлын дүнгээс 279,765.8 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Төслийн хүрээнд бий болсон 37,329.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнаагүй.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	ФТХ	АХГ-2022/51/НА-СТА-ТШЗ	Үр дүнгийн тайлангийн эхний үлдэгдлийг 155,208.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн	СҮДТ-ийн эхний үлдэгдлийг залруулсан	1	155,208.5	1	155,208.5							
2	ФТХ	АХГ-2022/42/НА-СТА-ТХН	Үндсэн хөрөнгийн хураангуй, дэлгэрэнгүй бүртгэлийн эхний үлдэгдэл 203.9 мянга, орлогын дүн 853.0 мянга, нийт 1,056.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.	ҮХ-ийн дэлгэрэнгүй бүртгэлд залруулга хийсэн	1	1,056.9	1	1,056.9							
3	ФТХ	АХГ-2022/42/НА-СТА-ТХН	Үндсэн хөрөнгийн элэгдлийн дэлгэрэнгүй бүртгэлийн дүн тайлант онд байгуулсан элэгдлийн зардлын дүнгээс 279,765.8 мянган төгрөгөөр зөрүүтэй	СБТ, үр дүнгийн тайлан, ҮХ-ийн дэлгэрэнгүй бүртгэлд залруулга хийсэн	1	279,765.8	1	279,765.8							
4	ФТХ	АХГ-2022/42/НА-СТА-ТХН	Төслийн хүрээнд бий болсон 37,329.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнаагүй.	СБТ, үр дүнгийн тайлан, ҮХ-ийн дэлгэрэнгүй бүртгэлд залруулга хийсэн	1	37,329.3	1	37,329.3							
Дүн					4	473,360.5	4	473,360.5	-	-	-	-	-	-	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ФТХ	АХГ-2022/42/НА-СТА-ТХН	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд 2,181,572.6 мянган төгрөгийн мэдээллийг ил тод байршуулахаас 7,692.6	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь	1	7,692.6							1	7,692.6	

Физик технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй, байршуулбал зохих 173 мэдээллээс 171-ийг хугацаанд, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	бүрэн байршуулж ажиллах												
Дүн				1								1	7,692.6		
Нийт дүн				5	481,053.1	4	473,360.5	-	-			1	7,692.6		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 160/А0150058

Улаанбаатар х

АХГ-0202/51/НА-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Физик, технологийн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 7,692,600.00 төгрөгийг худалдан авалтын мэдээллийг байршуулаагүй, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллээ хугацаанд нь байршуулаагүй зөрчил гаргасан, тооцооны нягтлан бодогч Алтангэрэл овогтой Цэрэндолгорт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Физик, технологийн хүрээлэнгийн захирал Ж.Давансамбууд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

АККАУНТ ТРАСТ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

П.НАРАНЦЭЦЭГ

